ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
# ТУШААЛ

2025 оны 03 сарын 27 өдөр Дугаар А/65 Улаанбаатар хот

### Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 59 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар батлалсугай.

2.Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар ханган хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АЛТАНЦЭЦЭГ

1525 010068

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 20.25. оны .03. дугаар сарын .07.-ны өдрийн А/65 дугаар тушаалын хавсралт

## Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

| д/д | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хариуцах газар, хэлтэс | Хугацаа |
|---|---|---|---|---|---|
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1.АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг агентлагийн албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк), мөн лед дэлгэц, байгууллагын мэдээллийн самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; | -Баримтжуулсан байх<br>-Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо)<br>-Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх. | Авлигатай тэмцэх газар, Захиргаа, удирдлагын газар | Тухай бүр |
| | | 1.2.Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах | -Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх.<br>-Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх.<br>-Үр дүнг тооцсон байх | Авлигатай тэмцэх газар, Захиргаа, удирдлагын газар | Жилдээ |
| | | 1.3. Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном, гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах шүгэл үлээхийг сурталчлан | -Мэдээллийг АТГ-аас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх<br>-Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү | Захиргаа, удирдлагын газар | Тухай бүр |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах | чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх<br>-Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх<br>-Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших | | |
| | | 1.4.Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх. | -Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, агентлагийн албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк) мөн лед дэлгэц, байгууллагын мэдээллийн сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх;<br>Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх. | Захиргаа, удирдлагын газар | Тухай бүр |
| 2 | Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх | 2.1.“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх; | -Журамд заасны дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагааны 1-ээс доошгүй чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр сонгосон байх.<br>-Сонгосон чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалт зарласан байх.<br>-Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх<br>-Үр дүнд суурил арга хэмжээг зохион байгуулсан байх. | Захиргаа, удирдлагын газар | III, IV улиралд |
| | | 2.2.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх | -Салбартаа үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгааг гаргасан байх.<br>-Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсан байх | Бүх газар, хэлтэс | Жилдээ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | -Үр дүнг тооцож, тайлагнасан байх. | | |
| | | 2.3.Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах | -2025 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд тогтмол ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлэх.<br>-Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх. | Захиргаа удирдлагын газар | Жилдээ |
| | | 2.4.Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших | -Байгууллагын үйл ажиллагааг, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээллийг судалгааг тогтмол гаргаж, тайлагнах.<br>-Хуулийн хүрээнд шуурхай бодитой шийдвэрлэж хэвших.<br>-Иргэд олон нийтээс байгууллагын үйл ажиллагаа хүнд суртал чирэгдэл, холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүн д суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх. | Захиргаа удирдлагын газар | Жилдээ |
| | | 2.5.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан | -Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх. | Захиргаа удирдлагын газар | Жилдээ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх; | -Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах.<br>-Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | | |
| 3 | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 3.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах | -Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс судалгаа, санал асуулга авах;<br>-Дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх;<br>-Хэрэгжилтийг тайлагнах. | Авлигатай тэмцэх газар, Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар | III, IV улиралд |
| | | 3.2.Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх; | -Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлж хэвших;<br>-Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан эрсдэлийг тодорхойлсон байх;<br>-Эрсдэлийг арилгах арга хэмжээнд дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулсан байх; | Захиргаа удирдлагын газар, ЭБАТ | Жилдээ |
| | | 3.3.Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан | -Төлөвлөгөөний 1.1-3.2 дахь хэсэгт заасан арга хэмжээтэй агуулгаараа давхцахгүй байх;<br>-Байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй төрийн үйлчилгээний онцлогт тохируулан зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг | Бүх газар хэлтэс | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх | олон нийтэд мэдээлсэн байх;<br>-Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, албан бичгийн хэрэгжилтийг хангасан байх;<br>-Үйлчилгээ авдаг, хамтарч ажилладаг, зорилтот бүлэгт урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, хийсэн өөрчлөлт, хүрсэн үр дүнгийн талаар мэдээлэл хүргэсэн байх. | | |
| | | 3.4.Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнг тодорхойлж, үйл ажиллагаандаа зохих арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. | -Бодитой үр дүнг тооцсон байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх | Захиргаа, удирдлагын газар | IV улиралд |
| 4 | Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах | 4.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх; | -Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Захиргаа, удирдлагын газар, Ёс зүйн дэд хороо | Тухай бүр |
| | | 4.2.Хамтран ажилладаг эм зүйн холбоод, эм хангамжийн байгууллагууд, төрийн бус байгууллага, гэрээт шинжээчид авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах. | -Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Бүх газар, хэлтсүүд хамтрах | Жилдээ |
| 5 | Байгууллагын удирдлагын | 5.1.Байгууллагаас жил бүр эрхлэн гаргадаг “Эмийн мэдээлэл сэтгүүл”-д | | Захиргаа, удирдлагын | III, IV улиралд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр нийтлэл болон зурагт хуудсыг хэвлүүлнэ. | -Товхимолд нийтлэл болон зурагт хуудсыг хэвлүүлсэн байх | газар, Эмийн аюулгүй байдлын тандалт судалгааны газар | |
| | | 5.2.Авлигын эсрэг хууль холбогдох дүрэм, журмын талаарх мэдлийг сорьж нийт албан хаагчдын дунд АХА тэмцээн зохион байгуулах; | -Албан хаагчдын тэмцээнд оролцсон ирц, чанар | Бүх газар, хэлтэс | II, IV улиралд |
| | | 5.3.Нийт албан хаагчдын дунд Авлигын эсрэг хууль холбогдох дүрэм, журмыг талаарх сургалтыг зохион байгуулах; | -Албан хаагчдын сургалтад хамрагдсан тоо, чанар | Авлигатай тэмцэх газар, Захиргаа, удирдлагын газар | III, IV улиралд |